“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

2026 оны 06 дугаар сарын 25 Улаанбаатар хот


Аян, олон нийтийн арга хэмжээний хүрээнд зарлагдсан хугацаа, чиглэлийн дагуу төлөвлөгөө, удирдамжийг тухай бүр боловсруулан хэлтсийн даргаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан хангаж ажиллав. Хэрэгжилтийн явц, үр дүнгийн биелэлтийг нэгтгэн, тайлан мэдээг хугацаанд нь холбогдох байгууллага, албан тушаалтанд тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

Аян, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулсан ажлын хүрээнд:

2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар нийт 5 олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 147 албан хаагч хамрагдав.

- Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж буй “Харилцан хүндэтгэе” аянд-109
- Бүх нийтийн цэвэрлэгээ-17
- "Мод тарих арга хэмжээнд-1
- *“Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд чухал”-10*
- *Хотын аж ахуйн ажлыг эрчимжүүлэх 21 хоногийн аян*
- Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт-
- “Улаабаатар марафон 2026”

2025-2026 оны хагас жилийн байдлаарх олон нийтийн арга хэмжээний хамрагдалтын харьцуулалт




Нийтийн их цэвэрлэгээ:

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Нийслэлийн нутаг дэвсгэрт бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах хуваарь батлах тухай” А/02 дугаар тушаалын дагуу Улаанбаатар хотын захирагчийн албанаас 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Их цэвэрлэгээ зохион байгуулах тухай 01/242 ирүүлсэн албан бичгийн дагуу 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 10:00-11:30 цаг хүртэл нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг цэвэрлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын нийт 17 албан хаагч хамрагдсан.

Албан хаагчид Автобусны буудлын эцсүүд (Яармагийн 1-р буудал, Яармагийн 2-р буудал, Яармагийн 3-р буудал, Эмнэлэгийн буудал)-ийн урд болон хойд хэсгийн түүвэр хог хаягдлыг цэвэрлэн нийт 8 шуудай хуурай хог хаягдлыг уутлан зориулалтын газарт тээвэрлэхэд бэлтгэн ажилласан. Тус ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийг ханган 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн "Хариу хүргүүлэх тухай" 01/805 дугаартай албан бичгээр Бүх нийтийн их цэвэрлэгээнд хамрагдсан тухай илтгэх хуудсыг "Улаанбаатар хотын шуурхай удирдлага зохицуулалтын төв" ОНӨТҮГ-т хүргүүлэв. Мөн газрын цахим хуудас, erp.ulaanbaatar.mn сайтад мэдээллийг бэлтгэн байршуулав.







“Тэрбум мод” үндэсний өдөр:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны “Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлэх тухай 58 дугаар зарлиг, 2025 оны "Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 44 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчийн баталсан 2026 оны хаврын "Мод тарих арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг ханган, “Байгальд өгсөн бүхэн буцаж ирдэг” уриан дор 2026 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Налайх дүүргийн ‘’Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэн’’-д нийт 20 ширхэг Миндаль модыг, 11 албан хаагч тарьж усалгаа хийв. Мод тарьсан тухай мэдээллийг бэлтгэн, 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Газрын цахим сүлжээ https://invest.ub.gov.mn/ болон ERP системд байршуулав



2025 оны хагас жилийн байдлаар нийт 6 удаа, 2026 оны хагас жилийн байдлаар нийт 5 удаагын аян зохион байгуулагдсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад аян зохион байгуулалтын давтамж буурсан үзүүлэлттэй байна.



“Харилцан хүндэтгэе” аян:

Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг аянд нэгдэж, Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж, нийт 4 арга хэмжээнд 90 албан хаагч хамрагдсан. Үүнд:

Албан хаагчдын хүндлэл, итгэлцэл, эерэг харилцааг төлөвшүүлэх, албан хаагчдын ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх зорилготой “Харилцан хүндэтгэе” уриалгыг бэлтгэн Ulaanbaatar.erp системд байршуулсан. Мөн “Байгууллагын дотоод уур амьсгалыг сайжруулах, ажлын байрны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилготой **“Эерэг үг - Эерэг өдөр”** постер, мэдээллийг бэлтгэн дотоод сүлжээнд байршуулсан.



Мөн аяны хүрээнд албан хаагчдын хамтын ажиллагаа, харилцан хүндэтгэл, ажлын байрны эерэг уур амьсгалыг дэмжих зорилгоор **“Эерэг хандлага-Эерэг орчин”** угтах өдөрлөгийг зохион байгуулж, хэлтэс бүр хуваарийн дагуу идэвхи санаачлагатай оролцсон.



Аяны төлөвлөгөөний дагуу хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, харилцан талархах соёлыг түгээх зорилгоор **“Талархлын мод”** арга хэмжээг зохион байгуулж, албан хаагчдаас ирүүлсэн талархлын үг сэтгэгдлийг холбогдох хэлтэс, албан хаагчдад хүргүүлэн ажилласан.



“Улаанбаатар марафон 2026”

Улаанбаатар марафон-2026" олон улсын гүйлт 2026 оны 05 дугаар сарын 23-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж албан хаагчид амжилттай оролцож хувийн амжилтаа ахиулан оролцлоо.

Марафонд нийт 27 албан хаагч оролцож ажилтнуудын бүртгэлийг Hipay application, Ulaanbaatar marathon.mn цахим системээр баталгаажуулав.Үүнээс 5км-т

10, 10км-т 16, 21 км-т 8 албан хаагч оролцохоор бүртгүүлэн 27 ажилтан амжилттай оролцсон.






Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага, сургалт


Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, мөн оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг 340 дүгээр тогтоолоор тус тус баталсан.

Тус журмуудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 16:00 цагт улс, орон даяар зохион байгуулагдах гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага сургуульд Манай газрын нийт ажилтнууд идэвхтэй хамрагдлаа.









“Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд чухал” аян:

2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 21-ний өдрүүдэд Олон улсын эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн 7 хоног тохиож байгаатай холбогдуулан Нийслэлийн Эрүүл мэндийн газраас “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд чухал” уриатай цахим аянд нэгдэж, аяны хүрээнд зохион байгуулах ажлын удирдамжийг батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласан.

Үүнд:

Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, эрүүл мэнддээ тогтмол анхаарах хандлагыг нэмэгдүүлэх зорилготой “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд чухал” уриалга, мэдээллийг бэлтгэн Ulaanbaatar ERP систем болон, дотоод сүлжээнд байршуулсан.


Газрын эрэгтэй албан хаагчдын эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох цахим судалгааг зохион байгуулж байна. Судалгааны дүн боловсруулагдаж байгаа бөгөөд үр дүнд үндэслэн эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлын чиглэлийг тодорхойлон хэрэгжүүлэхээр ажилласан.







Газрын эрэгтэй албан хаагчдын эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох цахим судалгаа бэлтгэж 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдөр тус судалгааг (TEAMS) байршуулав.



Судалгааны үр дүнгээс харахад эрэгтэй албан хаагчдын дунд урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамрагдалт харьцангуй сайн байгаа боловч нийт оролцогчдын 40 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй байна. Мөн ихэнх албан хаагч долоо хоногт 1–2 удаа дасгал хөдөлгөөн хийдэг хэдий ч өдөрт 5–6 цаг унтдаг, эрүүл хооллолтын зарчмыг тогтмол мөрддөггүй, тамхины хэрэглээ 50 хувьтай байгаа нь эрүүл амьдралын хэвшлийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь ажлын стрессийг дунд болон их түвшинд гэж үнэлсэн бөгөөд стресс нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйл гэж үзжээ. Стрессээ даван туулах эерэг арга хэлбэрүүдийг ашиглаж байгаа боловч зарим оролцогч архи, тамхи хэрэглэдэг гэж хариулсан нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.

Түүнчлэн эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаарх мэдээллийг оролцогчдын 90 хувь нь сошиал орчноос авч байгаа нь үнэн зөв, баталгаатай мэдээллийг байгууллагын дотоод сувгаар тогтмол хүргэх шаардлагатайг харуулж байна. Иймд эрэгтэй албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах, эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөн, стрессийн менежментийг дэмжсэн нөлөөллийн арга хэмжээг цаашид тогтмол зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Хотын аж ахуйн ажлыг эрчимжүүлэх 21 хоногийн аян:

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн “Удирдамж хүргүүлэх тухай” 01/1172 дугаар албан бичгийн дагуу тус албаны 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн “Хотын аж ахуйг эрчимжүүлэх 21 хоногийн аян зохион байгуулах тухай” 5 дугаартай удирдамж болон Нийслэлийн Засаг даргын 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн “Хотын аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаварын дагуу “Хотын аж ахуйн ажлыг эрчимжүүлэх 21 хоногийн нөлөөллийн аян”-д нэгдэж, аяны хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна




БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Г.АНЗОРИГ
2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

"НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ
ХОТЫН АЖ АХУЙН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ 21 ХОНОГИЙН АЯНЫ ХҮРЭЭНД ХИЙХ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны 06 дугаар сарын 10 Улаанбаатар хот

Д/д	Харагчүүлэх ажил	Хугацаа	Хамрах хүрээ	Нэмэлт тайлбар	Харчуулах албан хаагч
1	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн "Хотын аж ахуйн ажлыг эрчимжүүлэх 21 хоногийн аян зохион байгуулах тухай" 08 дугаар удирдамжийг газрын нийт ажилтан, албан хаагчид, хэлтсийн инженерүүдэд танилцуулах	2026.06.10	Газрын нийт ажилтан, албан хаагчид	Постер, мэдээ бэлтгэн хүргэх	ЗХ-ийн мэргэжилтэн Д.Баасанхүү, БЗХХ-ийн Баруун бүсийн Ахлах инженер Н.Энхбаяр, Орчны тохижилт , ногоон байгууламжийн бүсийн Ахлах инженер С.Арнуунуул, Барилтын хяналтын инженер А.Дамбадаева
2	Газраас техникийн хяналт хэрэгжүүлэн ажиллах байгаа инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн тесөл, арга хэмзээний жагсаалтыг гаргах, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр арга хэмзээ авч ажиллах	2026.06.10 2026.07.08	БЗХХ,ЗХ, МТХ	Тухай бүрт фото мадээ постер мадээлэл бэлтгэн тайлагнах	БЗХХ-ийн Баруун бүсийн Ахлах инженер Н.Энхбаяр, Барилтын хяналтын инженер А.Дамбадаева
3	Газраас техникийн хяналт хэрэгжүүлэн ажиллах байгаа Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх тесөл, арга хэмзээний жагсаалтыг гаргах, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр арга хэмзээ авч ажиллах	2026.06.10 2026.07.08	БЗХХ,ЗХ, МТХ	тухай бүрт фото мадээ постер мадээлэл бэлтгэн нийтлэх	БЗХХ-ийн Орчны тохижилт , ногоон байгууламжийн бүсийн Ахлах инженер С.Арнуунуул



4	Газраас техникийн хяналт хэрэгжүүлэн ажиллах байгаа нийтийн зэзмшлийн гудамж, зам талбайн тохижилтын тесөл, арга хэмзээний жагсаалтыг гаргах, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр арга хэмзээ авч ажиллах	2026.06.10 2026.07.08	БЗХХ,ЗХ, МТХ	Хийдсэн ажлын үр дүнг тухай бүр нийтлэх	БЗХХ-ийн Орчны тохижилт, ногоон байгууламжийн бүсийн Ахлах инженер С.Арнуунуул
5	Аяны хүрээнд инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн тесөл, арга, ногоон байгууламжийн тесөл, арга хэмзээ, нийтийн зэзмшлийн гудамж, зам талбайн тохижилтын тесөл, арга хэмзээний хэрэгжилтийн явцын талаарх мадээ, бэлтгэн гаврын цахим худдасвар иргэд, олон нийтэд суртачлан ажиллах	2026.06.10 2026.07.08	БЗХХ,ЗХ, МТХ	Аяны ур дүнг нэгтгэн тухай бүр тайлан мадээ боловсруулж нийтлэх	ЗХ-ийн мэргэжилтэн Д.Баасанхүү, МТХ-ийн мэргэжилтэн Д.Оюунбилэг
6	Аяны явцын мадээг долоо хоног бүрийн Пүрэв гарагт Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэх	2026.06.18 2026.06.25 2026.07.02 2026.07.08	БЗХХ,ЗХ, МТХ	Аяны хэрэгжилтийн талаар мадээллийг долоо хоног бүр холбогдох байгууллагад хүргүүлэх	Захиргааны хэлтсийн мэргэжилтэн Д.Баасанхүү

Удирдамжид заасны дагуу аяны явцын үр дүнгийн тайланг 7 хоног бүрийн пүрэв гарагт буюу 2026 оны 06 дугаар сарын 18, 25, 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд Хяналт, үнэлгээний газарт хүргүүлэхээр ажиллаж байна. Тайлант хугацаанд аяны тайланг 2026 оны 06 дугаар сарын 18, 25-ны өдрүүдэд хүргүүлж, 2026 оны 06 дугаар сарын 10-наас 18-ны өдөр болон 06 дугаар сарын 19-өөс 25-ны өдрүүдэд хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаарх тайланг хүргүүлэв.

Тайлант хугацаанд дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

Аяны хугацаанд төлөвлөгөөнд тусгагдсан мэдээ, постер бэлтгэв.

- Газрын нийт ажилтан, албан хаагчдад аяныг таниулах, аянд нэгдэж байгаа тухай агуулга бүхий мэдээлэл, постерыг дотоод сүлжээ (TEAMS)-д байршуулав.







Хэрэгжүүлж буй бүтээн байгуулалт, тохижилтын ажлууд:

1.1 Инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах:

Манай газарт инженерийн шугам сүлжээ дэд бүтцийн төсөл, арга хэмжээний хүрээнд 518.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 129 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд 58 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Үүнээс 2025-2026 он дамжин хэрэгжиж байгаа 103 төсөл, арга хэмжээ 70 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол 2026 онд шинээр хэрэгжих 26 төсөл, арга хэмжээ дундаж 8 хувийн гүйцэтгэлтэй байна. Ажил эрчимжүүлэх чиглэлээр хяналтын инженерүүд өдөр бүр барилгын талбайд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд, шаардлагатай тохиолдолд тухай бүр ажил эрчимжүүлэх шаардлага, мэдэгдлийг албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.

1.2 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах:

Нэгдсэн Үндэсний байгууллагын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурал манай улсад 2026 оны наймдугаар сарын 17-ноос 28-ны өдрүүдэд зохион байгуулагдана. Хурлын бэлтгэл ажлын хүрээнд нийслэлийн зүгээс түр байгууламж барих, авто зам, тохижилт болон шугам сүлжээний ажлыг хариуцан ажиллаж байна. Одоогийн байдлаар тус хурлын зохион байгуулалтад зориулж нийт 80 мянган ам метр талбайд дугуйн зам, явган хүний зам болон авто зогсоолын тохижилтын ажлыг гүйцэтгэж байна. Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын Конвенцын талуудын 17 дугаар бага хурал /COP-17/-ын түр барилга, байгууламжийн мод тарилт, зүлэгжүүлэлтийн ажил өнөөдрийн байдлаар 70 хувьтай үргэлжилж байна.





1.3 Гудамж, зам талбайн тохижилтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах:


2026 онд 69 700 м2 хуучин явган замыг байгалийн чулуугаар хучихаар төлөвлөсөн. Нийт 12 байршилд хэрэгжихээс Их тойруу, Энхтайваны өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөөний гудамжуудад 10 байршилд 10 гүйцэтгэгч компани ажиллаж байна. 2 байршлын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл хангуулсан. Нийт явган замын хучилтын ажлын гүйцэтгэл 52 хувьтай хэрэгжиж байна.





1.4 Үерийн далан, борооны ус зайлуулах шугамын цэвэрлэгээ, арчлалт, үерийн эрсдлээс хамгаалах арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах:


Үерийн эрсдлийг бууруулах ажлын хүрээнд Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн он дамжин хэрэгжиж буй 8 төсөл, арга хэмжээ 117,5 сая төгрөг, шинээр авто замын борооны ус зайлуулах шугам 413.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй барилга угсралтын нийт 66 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Газар чөлөөлөлт болон хөрөнгө шийдвэрлүүлэх, инженерийн дэд бүтцийн байгууллагатай зөвшилцөх мөн талбайн хяналтыг тогтмол тавин шаардлагатай тохиолдолд тухай бүр ажил эрчимжүүлэх шаардлага, мэдэгдлийг албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.





Ажил эрчимжүүлэх чиглэлийн хүрээнд:

Тус аяны хүрээнд ажлыг эрчимжүүлэх чиглэлээр хяналтын инженерүүд өдөр бүр барилгын талбайд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд гудамж, зам талбайн тохижилтын ажлыг эрчимжүүлэх талаар гүйцэтгэгч болон холбогдох бусад байгууллагуудад тухай бүр албан шаардлага, мэдэгдлийг албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна



НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР"
ОНӨААТҮГ

ГЕОДЕЗИ, УСНЫ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР ОНӨААТҮГ-Т

Шаардлага хүргүүлэх тухай

Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн Чингисийн өргөн чөлөө гудамж, АПУ-гийн уулзвараас ТЭЦ-3-ын уулзвар хүртэлх авто замын урд хэсгийн хуучин явган замыг байгалийн чулуун хавтангаар шинэчлэх ажил нь танай газрын хэрэгжүүлж буй барооны ус зайлуулах шугам угсралтын ажилтай уялдан хийдэж байна.

Гэвч өнөөдрийн байдлаар авто замын сэтгэлгээний ажил хийгдээгүйгээс шалтгаалан явган хүний зам хучилтын ажил хүлээгдэвэд байна.

Иймд барооны ус зайлуулах шугам угсралтын ажлыг яаралтай зохион байгуулж, хамтран ажиллана уу.

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨ ААТҮГ
Удирдлага
Дарга
Батбаатар Ганзориг
2026.06.05 16:19



НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР"
ОНӨААТҮГ

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР, ЗАМЫН ЦАГДААГИЙН ХЭЛТЭСТ

Хамтран ажиллах тухай

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/21 дүгээр захирамжаар батлагдсан Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажлын хүрээнд Сансарын тойргоос Зүүн 4 замын уулзвар хүртэлх хуучин явган замын хучилтыг байгалийн чулуун хавтангаар шинэчлэх ажил хийдэж байна.

Батлагдсан ажлын зургийн дагуу Зүүн 6-2-ийн ПК5+40-өөс ПК5+60 хэсэгт өртөж буй, Баянцээл худалдааны төвийн гадна байрлах цагдаагийн харуулын байрыг нүүлгэн шилжүүлэх шаардлагатай байгаа тул холбогдох арга хэмжээг авч хамтран ажиллана уу.

Хавсралт 1 хуудастай.

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨ ААТҮГ
Удирдлага
Дарга
Батбаатар Ганзориг
2026.06.08 08:28

Суртчилгаа, нөлөөллийн ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын санаачилсан **“Хотын аж ахуйн ажлыг эрчимжүүлэх 21 хоногийн аян”**-д Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар нэгдэн, хариуцсан бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж байна. Тус газар нь нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн хөгжүүлэлт, ногоон байгууламжийн нэмэгдүүлэлт, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тохижилтын бүтээн байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд дээрх аяны хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажлын талаар танилцуулсан мэдээллийн бичлэг бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулсан болно. **Бичлэгийн холбоос:** https://www.facebook.com/reel/1545474070580516

ЗАХИРГААНЫ ХЭЛТЭС